

UCS 1402C:2020

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ



Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага

**Улаанбаатар хот
2020 он**

ГАРЧИГ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
1. ЗОРИЛГО	3
2. ХАМРАХ ХҮРЭЭ	3
3. НОРМАТИВ ЭШЛЭЛ	3
4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ	3
5. ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧИНД ҮҮСЭХ НАРНЫ ХЭТ ХАЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГА	4
7. САРАВЧ, СҮҮДРЭВЧИНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	5
8. ТӨРӨЛ АНГИЛАЛ	9
9. САРАВЧ, СҮҮДРЭВЧ БАЙРЛУУЛАХ	10
10.САРАВЧ, СҮҮДРЭВЧ СУУРИЛУУЛАХ	10
11.БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ	11
12.ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ	11
13.САРАВЧ, СҮҮДРЭВЧНИЙ МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА	12
6. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	13
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	14
Хавсралт №1	15
Хавсралт №2	16
Хавсралт №3	17
Хавсралт №4	18
Хавсралт №5	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нарны замын тусгал.....	4
Зураг 2. Зуны нар буцах, хавар намрын өдөр шөнө тэнцэх, өвлийн нар эргэх өдрүүдийн нарны траектор	4
Зураг 3. Сүүдрийн агаарын температурт үзүүлэх нөлөө.....	5
Зураг 4. Хүүхдийн тоглоомын талбайн сүүдрэвч.....	6
Зураг 5. Саравчны шалны түвшин	7
Зураг 6. Саравч, сүүдрэвчийн хэсэглэлийн холбоос, бэхэлгээ /жишээ/	7
Зураг 7. Саравчны хаалганы зай хэмжээ.....	8
Зураг 8. Саравчны хана	8
Зураг 9. Саравч, сүүдрэвчний хогийн сав	9
Зураг 10. Сүүдрэвчний төрөл	9
Зураг 11. Саравч байрлуулах /жишээ/	10
Зураг 12. Саравч, сүүдрэвч суурилуулах хэсэглэл.....	10

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэг удаа үйлчлүүлэх хүний тоо.....	6
Хүснэгт 2. Ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл	11
Хүснэгт 3. Саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээ.....	12
Хүснэгт 4. Хийц эдлэлийн материал сонгох үнэлгээ	12
Хүснэгт 5. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	13

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь саравч, сүүдрэвч байрлуулах үйл ажиллагаанд нэгдсэн арга зүйн удирдамж өгч, хотын оршин суугчдын эрүүл ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, түүний чанар, загвар, суурилуулах, ашиглах болон хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гадна орчны тохижилтод саравч, сүүдрэвч хийж гүйцэтгэх, байршуулах иргэн, аж ахуй нэгж, энэ чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллага, орчны аюулгүй байдлын хяналт хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан барилгын норм ба дүрэм, стандартыг хэрэглэнэ. Эш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

БНБД 30-01-03 Хот тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм

БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж

БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны хорооллын нутаг дэвсгэрт нарны гэрлийн шууд тусгалын үргэлжлэх хугацааг төслийн шатанд тодорхойлох аргачилсан заавар

БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм

MNS 6751:2019 Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Сүүдрэвч – гэж нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан, 1 талдаа ханатай болон ханагүй, дээврээр нар салхинаас хамгаалсан байгууламжийг;

Саравч – гэж нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан, 2 болон түүнээс дээш талдаа ханатай, дээврээр нар салхинаас хамгаалсан байгууламжийг;

Нарны шууд тусгал – гэж нарны туяа ямар нэгэн барилга, байшин, мод, уул зэрэг биетэд халхлагдалгүйгээр шууд тусахыг;

Нарны хэт ягаан туяа – гэж үзэгдэх гэрлээс богино рентген туяанаас урт долгионы урттай цахилгаан соронзон цацралыг;

Гадна тохижилтын ажил – гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, авто зам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг;

Барилгын материал – гэж стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг;


Барилгын эдлэхүүн – гэж барилга байгууламж ба түүний бүтээцийн элементийн үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий эдлэлийг;

Архитектурын хориглох хийц – гэж нийтийн эзэмшлийн зам талбайн суухад тохиромжгүй, хориглосон, аюултай газруудад байрлуулсан хориглох үүрэгтэй хийцийг;

5. ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧИНД ҮҮСЭХ НАРНЫ ХЭТ ХАЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГА


- 5.1. Хот байгуулалт, барилга байгууламжийн зураг төслийн шатанд өрөө тасалгаанд болон хорооллын нутаг дэвсгэрт нарны шууд тусгалын үргэлжлэх хугацааг тодорхойлох нь нарны эерэг ба сөрөг үйлчлэлийг хүний эрүүл мэндэд зүй зохистойгоор зохицуулах ач холбогдолтой.
- 5.2. Саравч, сүүдрэвч байгуулахдаа нарны замын тусгалыг ойлгож төлөвлөхгүй бол хэт ягаан туяанд өртөхөөс хамгаалж, тав тухыг хангаж чадахгүй бөгөөд ашиглалтын шаардлага хангахгүй.
- 5.3. Нарны ээвэрлэлтийн шаардлагыг хангуулах, нарны илүүдэл цацрагаас хамгаалахын аль алиныг архитектур төлөвлөлтийн аргаар зохицуулах нь хамгийн ашигтай байдаг. Эдгээр аргуудад барилгын ориентацийг зөв сонгох, лож, веранд, тагт, галерей төлөвлөх, ногоон суулгамал хэрэглэх зэрэг аргууд орно. /Зураг 1/.

Зураг 1. Нарны замын тусгал




- 5.4. Улаанбаатар хот орших хойд өргөргийн $f=48^{\circ}$ -ын (Улаанбаатар хот нь $X\Theta 47^{\circ}56'$ дээр оршино) нутаг дэвсгэр дээгүүр өвөл зуны нар эргэх, буцах өдрүүд болон хавар намрын өдөр шөнө тэнцэх өдрүүдийн нарны траекторыг үзүүлэв. Үд дунд нарны өнцөг хавар намар 0° -тай тэнцүү байх ба зун, өвөлд харгалзан $+23,5^{\circ}$ ба $-23,5^{\circ}$ байна. Энэ тоо бүх өргөрөгт тогтмол байна /Зураг 2/.

Зураг 2. Зуны нар буцах, хавар намрын өдөр шөнө тэнцэх, өвлийн нар эргэх өдрүүдийн нарны траектор



- 5.5. Дээрх тооцооллыг БХБС -ын 2007 оны 179 -р тушаалаар батлагдсан “БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны хорооллын нутаг дэвсгэрт нарны гэрлийн шууд тусгалын үргэлжлэх хугацааг төслийн шатанд тодорхойлох аргачилсан заавар”-ийн дагуу гүйцэтгэнэ.
- 5.6. Хот байгуулалт, барилгажилтын төсөл /орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бичил хорооллын ерөнхий төлөвлөгөө, хот суурин газрын барилгажилтын төсөл/-д энэхүү нормоор шаардагдах нарны шууд тусгалын үргэлжлэх хугацааны шаардлагыг хэрхэн тооцож хангасан тухай болон ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлийн талаар тайлбар бичгийн хүрээлэн буй орчныг хамгаалах бүлэгт тусгай дэд бүлэг болгон бичиж оруулна (БНБД 23-04-07).
- 5.7. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ерөнхий боловсролын болон дотуур байртай сургууль, эрүүл мэнд, эмчлэн сэргийлэх байгууллага, амралт, сувиллын газар дахь үндсэн үүрэг зориулалтын өрөө тасалгааны байрлал, чиглэлийг нормчлогдсон улиралд тусах нарны шууд тусгалын тасралтгүй үргэлжлэх хугацаа өдөрт 3 цагаас багагүй байхаар төлөвлөнө (Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж, БНБД 23-04-07).
- 6.7. Нарны тусгалын үргэлжлэх норматив хугацааг дараах талбайд заавал хангуулна. Үүнд:
- 6.7.1. Орон сууцны хорооллын хүүхэд тоглох болон биеийн тамирын талбай,
 - 6.7.2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоглоомын болон биеийн тамирын талбай,
 - 6.7.3. Ерөнхий боловсролын болон дотуур байртай сургуулийн биеийн тамир, амралт, сургалт-туршлагын талбай (Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж, БНБД 23-04-07).
- 6.8. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалахын тулд шууд ба шууд бус хэт ягаан туяанаас хамгаалах гадна орчныг бий болгох шаардлагатай /Зураг 3/.

Зураг 3. Сүүдрийн агаарын температурт үзүүлэх нөлөө



- 6.9. Хорооллын талбайг нарнаас хамгаалахдаа барилгаар сүүдэрлэх, орчныг тохижуулж, тусгай сүүдрэвч хийх буюу мод тарих аргаар шийдвэрлэнэ (Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж, БНБД 23-04-07).

7. САРАВЧ, СҮҮДРЭВЧИНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1. Саравч, сүүдрэвч нь хотын өнгө үзэмжид барилга архитектурын шийдлийг тодорхойлох хэрэгсэл төдийгүй, иргэдийн ая тухтай амарч, зугаалах боломжийг бүрдүүлдэг чухал байгууламж юм.
- 7.2. Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны

дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөх бөгөөд амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц бусад барилга байгууламж төлөвлөхийг хориглоно (Хот байгуулалтын тухай хууль 14.1).

- 7.3. Нийтийн хэрэгцээний нутаг дэвсгэрийг усан оргилуур, усан сан, шат, налуу зам, саравч, сүүдрэвч, гэрэлтүүлэг зэрэг архитектурын жижиг хэлбэрээр тоноглож тохижуулан төлөвлөнө (БНБД 30.01.03-4.9).
- 7.4. Хотын хүн амын суурьшлын бүсээс хамааруулан цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж бүхий газрын 1 удаад үйлчлэх хүний тоо хэмжээг тооцон гаргадаг. Ногоон бүс, ой, ойн бүс, цэцэрлэгт хүрээлэнд нэгэн зэрэг үйлчлүүлэх хүний тоог доор зааснаас ихгүйгээр тооцож төлөвлөнө (БНБД 30.01.03-4.5).
- 7.5. Нэг удаа үйлчлүүлэх хүний тооноос хамааран саравч, сүүдрэвч, сандлыг хангалттай хэмжээгээр тооцож байрлуулах бөгөөд хүн/га-д оногдох хэмжээг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Нэг удаа үйлчлүүлэх хүний тоо

Төрөл	Тоо хэмжээ (хүн/га)
Хотын цэцэрлэгт хүрээлэнд	100
Амралт, зугаалгын орчны цэцэрлэг, ногоон бүсэд	70
Амралт сувиллын тосгоны ногоон бүсэд	50
Ойн төгөл, нуган төгөл, усан хүрээлэн	10


- 7.6. Нийтийн эзэмшлийн талбайд саравч сүүдрэвчийг төлөвлөхдөө явган зорчигчийн аюулгүй байдал, саадгүй зорчих нөхцөлийг хангах ба UCS 0901B:2020 баримт бичгийн шаардлагыг хангасан байна.
- 7.7. Саравч, сүүдрэвчийг төлөвлөхдөө явган хүний замыг тасралтгүй үргэлжлэх байдлаар төлөвлөнө.
- 7.8. Хүүхдийн тоглоомын талбайд элсээр тоглох хэсэг байгуулсан бол сүүдрэвчийг заавал байрлуулна (MNS 6751:2019), (Зураг 4).

Зураг 4. Хүүхдийн тоглоомын талбайн сүүдрэвч




- 7.9. Нийгмийн хэрэгцээний иргэд олноор төвлөрдөг газруудад нар салхинаас хамгаалах зорилгоор сандал, саравч, сүүдрэвчийг хүн амын төвлөрлийн тоо хэмжээтэй уялдуулан байгуулах шаардлагатай.
- 7.10. Нийтийн тээврийн автобусны зогсоолын саравч нь UCS 1601В:2020 стандартын шаардлагыг хангасан байна.
- 7.11. Нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулах саравч, сүүдрэвчинд орж гарахад зориулсан шалыг явган зам, талбайтай нэг түвшинд, хаалгыг босгогүй хийнэ (Зураг 5).

Зураг 5. Саравчны шалны түвшин



- 7.12. Саравч, сүүдрэвчний бүрдэл хэсгийг холбож угсрахад хялбар байх шаардлагатай бөгөөд эвдэрсэн тохиолдолд солих буюу засварлахад энгийн байвал зохино (Зураг 6). Жишээ нь: Углуурга, оньс зэрэг холбоос бэхэлгээг сольж угсрахад хялбар байх шийдлийг сонгон хэрэглэнэ.

Зураг 6. Саравч, сүүдрэвчийн хэсэглэлийн холбоос, бэхэлгээ /жишээ/




- 7.13. Саравчинд орох гарах хаалга, тэргэнцэртэй иргэнд зориулсан талбайн өргөн 0.9 м, урт нь 1.5 м-ээс багагүй байна. Нэвтрэх хаалганы өндөр 2.1 м-ээс багагүй байна (БД 31-112-11, 3.1). Саравчны хаалганы зай хэмжээг Зураг 7-д үзүүлэв.



- 7.14. Саравч, сүүдрэвчинд нөлөөлөх салхины хурд, салхины ба цасны ачааллыг тооцож бат бэх хийвэл зохино.
- 7.15. Саравчны ханыг салхи чөлөөтэй нэвтрүүлэх боломжтой байдлаар төлөвлөх нь тохиромжтой (Зураг 8).


Зураг 8. Саравчны хана



- 7.16. Хогийн савыг байрлуулах тохиромжтой байрлал нь сандал суудлаас 3-аас 14 метр зайд байрлуулах нь тохиромжтой гэж үздэг боловч тодорхой заах боломжгүй учир орох хаалга, гарц, бие засах газар, явган хүний зам, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол болон бусад ачаалал ихтэй газрын ойролцоо байрлуулна.

- 7.17. Саравч, сүүдрэвчний дотор талд хогийн сав байрлуулах нь тохиромжгүй бөгөөд хөдөлгөөний эрчим төвлөрч байгаа газруудад хог хаягдлыг ангилан хаях боломжтой байна.
- 7.18. Хогийн савыг байрлуулахад UCS1403C:2020 стандартын шаардлагыг хангасан байна.
- 7.19. Саравч, сүүдрэвчний дотор талд хогийн сав байрлуулах нь тохиромжгүй бөгөөд хөдөлгөөний эрчим төвлөрч байгаа газруудад хог хаягдлыг ангилан хаях боломжтой байна (Зураг 9).

Зураг 9. Саравч, сүүдрэвчний хогийн сав



8. ТӨРӨЛ АНГИЛАЛ

- 8.1. Нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвчний хийсэн материалаас нь хамааруулж модон, төмөр, шилэн /хатжуулсан/ гэж ангилна (Зураг 10).
- 8.2. Саравч, сүүдрэвчийг дээрх материалуудыг хослуулан архитектур, ландшафтын шийдлээр өнгө үзэмтэй, бат бөх, чанартай, хүртээмжтэй байхаар төлөвлөж хийнэ.

Зураг 10. Сүүдрэвчний төрөл

Төмөр сүүдрэвч



Модон сүүдрэвч



Шилэн сүүдрэвч



Төмөр саравч



Модон саравч




Шилэн саравч



9. САРАВЧ, СҮҮДРЭВЧ БАЙРЛУУЛАХ

- 9.1. Саравч, сүүдрэвчийг иргэдийн олноор төвлөрөх газруудад нар, салхинаас хамгаалах зорилгоор байрлуулна.
- 9.2. Явган хүний замын зорчих хэсэгт саад болохоор газарт байрлуулахыг хориглоно.


Зураг 11. Саравч байрлуулах /жишээ/



10. САРАВЧ, СҮҮДРЭВЧ СУУРИЛУУЛАХ

- 10.1. Саравч, сүүдрэвчийг суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгыг урьтал болгоно.
- 10.2. Саравч, сүүдрэвчийг газарт хөдөлгөөнгүй суурилуулах бөгөөд суурийн бетон эдлэлд зөвхөн тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 10.3. Саравч, сүүдрэвчний үндсэн хийц эдлэхүүний нийт жингээс хамааруулан суурийн бетон эдлэлийн хэмжээг тооцно.
- 10.4. Саравч, сүүдрэвчийг суурилуулах суурийн хэсэглэлийг Зураг 12-д үзүүлэв.

Зураг 12. Саравч, сүүдрэвч суурилуулах хэсэглэл



11. БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

- 11.1. Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэнд байгуулсан саравч, сүүдрэвчийг өмчлөгч, ашиглагч байгууллага бүртгэх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх, ашиглах журмыг мөрдлөг болгоно.
- 11.2. Хотын оршин суугчид нь нэгдсэн төлөвлөлт, зураг төсөл, менежментээр дамжуулан саравч, сүүдрэвчийг зориулалтын дагуу, соёлтой ашиглах үйл ажиллагааг дэмжих ёстой.
- 11.3. Саравч, сүүдрэвчийг зүй бусаар ашиглах, хохирол учруулах, сүйтгэх, устгах, гэмтээх, зүй зохисгүйгээр ашиглахыг хориглоно.
- 11.4. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг өмчлөгч, ашиглагч байгууллага засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэнэ.
- 11.5. Засвар үйлчилгээ хийх байгууллага нь засвар үйлчилгээний хяналт хийх хүснэгтийг ашиглавал зохино.

12. ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- 12.1. Нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвч нь бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулах болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ. Ашиглалтын хяналт үнэлгээ хийх чиглэлийг Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Ашиглалтын байдалд хяналт үнэлгээ хийх чиглэл

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдолтой эсэх /тоос, шороо, тосны бохирдол/	☐	☐
2	Гадарга бүрэн бүтэн байдалтай эсэх	☐	☐
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан, гээгдсэн эсэх	☐	☐
4	Шавж хорхойд идэгдсэн эсэх	☐	☐
5	Модон эдлэхүүний хугарсан гэмтсэн эсэх	☐	☐
6	Ялзрал, зэврэлттэй эсэх	☐	☐
7	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	☐	☐

Тайлбар: Саравч, сүүдрэвч нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

13. САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 13.1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагыг бүрэн хангасан барилгын материалаар хийгдсэн байна.
- 13.2. Саравч, сүүдрэвчийн модон хийцийн эдэлгээг уртасгах зорилгоор ус чийг тусгаарлах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 13.3. Саравч, сүүдрэвчийн металл хийц хэсгүүдийг зэвэрдэггүй материалаар хийх, аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэгийг стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 13.4. Саравч, сүүдрэвчийн эдлэхүүнийг шилээр хийх тохиолдолд ганшуулсан шил, поликарбонат материал ашиглах шаардлагатай.
- 13.5. Монгол орны цаг уурын эрс тэрс нөхцөл байдалд нийтийн эзэмшлийн зам талбай цэцэрлэгт хүрээлэнд байрлуулах саравч, сүүдрэвч, түүний суудлыг модон материалаар хийх нь нэн тохиромжтой юм.
- 13.6. Доор хүснэгтэд саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Саравч, сүүдрэвч хийх материалын тохиромжтой байдлын үнэлгээ

Үзүүлэлт	Үндсэн материалын төрөл			
	Мод	Шил	Хуванцар	Металл
Тухтай байдал				
Температурын өөрчлөлтөд дулаан, хүйтнийг дамжуулахгүй байх шинж чанар				
Будах шаардлагатай				
Цэвэрлэгээний шаардлага				
Хүйтэн цаг уурт хайрахгүй, жиндүүлэхгүй байх шинж чанар				

Тохиромжтой Тохиромж багатай Тохиромжгүй

- 13.7. Саравч, сүүдрэвчийг байрлуулах талбайгаас хамааруулан хийц эдлэхүүний материалыг сонгох нь тохиромжтой. Тохиромжтой байдлын үнэлгээг Хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 4. Хийц эдлэлийн материал сонгох үнэлгээ

Үзүүлэлт	Үндсэн материалын төрөл			
	Мод	Шил	Хуванцар	Металл
Нийтийн эзэмшлийн зам талбайд				
Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжид				
Амралт, зугаалгын орчны цэцэрлэгт				
Ойн төгөл, нуган төгөл, усан хүрээлэн				
Автобусны зогсоол				

Тохиромжтой Тохиромж багатай Тохиромжгүй

6. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН САРАВЧ, СҮҮДРЭВЧИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Саравч, сүүдрэвчинд тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 5 -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 5. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Саравч, сүүдрэвчийг зөв байрлалд, зөв харуулж байршуулсан эсэх	☐	☐
2	Саравч, сүүдрэвчийн бүтээц, эдлэхүүн стандартын шаардлага хангасан эсэх	☐	☐
3	Саравч, сүүдрэвч нь нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвчний зай хэмжээний стандартад нийцэж байгаа эсэх	☐	☐
4	Саравч, сүүдрэвчийн модон хийц хэсгүүдэд байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
5	Саравч, сүүдрэвчийн металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
6	Саравч, сүүдрэвчийг стандартын дагуу суурилуулсан эсэх	☐	☐
7	Саравч, сүүдрэвчний шал явган зам, талбайтай нэг түвшинд байгаа эсэх	☐	☐
8	Саравч, сүүдрэвчийн сандал нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх	☐	☐


Тайлбар: Хотын нийтийн эзэмшлийн саравч, сүүдрэвч нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


- Хот байгуулалтын тухай хууль
- Барилгын тухай хууль
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны хорооллын нутаг дэвсгэрт нарны гэрлийн шууд тусгалын үргэлжлэх хугацааг төслийн шатанд тодорхойлох аргачилсан заавар
- БНБД 23-04-07 Орон сууц, олон нийтийн барилга, сууцны барилгажилтын бүсийн нарны тусгалын хангамж
- БНБД 30-01-03 Хот тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм
- БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
- MNS 6751:2019 Хүүхдийн тоглоомын талбай. Ерөнхий шаардлага
- UCS 0001-01:2019 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага
- UCS 1403C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулсан хогийн саванд тавигдах шаардлага
- UCS 1404C:2020 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулсан сандалд тавигдах шаардлага
- UCS 1601B:2020 Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага

САРАВЧ, СҮҮДРЭВЧ

ХАЖУУ ТАЛ /М1:100/




ШАЛНЫ БАЙГУУЛАЛТ /М1:100/




БАЙГУУЛАЛТ, ЗАЙ ХЭМЖЭЭ

ОГТ/ЛОЛ 1-1 /М1:100/




		САРАВЧ, СҮҮДРЭВЧ		САРАВЧНЫ НҮҮР ТАЛ, ОГТ/ЛОЛ, ШАЛНЫ БАЙГУУЛАЛТ	
		Архитектор	О.Билэгүүн	Х.С.-Дугаар: USC-14.02С	Масштаб: М1:100
Гүйцэтгэсэн		О.Билэгүүн	Зургийн дугаар: 01	Хуудас: 08	Огноо: 2020
Шалгасан		Б.Од-Эрдэнэ		Хянасан огноо: 2020	




САРАВЧ, СҮҮДРЭВЧ

СҮҮРИЙН ХЭСЭГЛЭЛ /М1:20/




ДЭЭВРИЙН ХЭСЭГЛЭЛ



ХЭСЭГЛЭЛ

ДЭЭВРИЙН ДАМНУРУУНЫ ХЭСЭГЛЭЛ /М1:10/



САРАВЧ, СҮҮДРЭВЧ				ХЭСЭГЛЭЛ			
Архитектор		О.Билэгүүн	Х.С.-Дугаар:	Масштаб:	Огноо:		
Гүйцэтгэсэн		О.Билэгүүн	USC-14.02C	М1:20	2020		
Шалгасан		Б.Од-Эрдэнэ	Зургийн дугаар:	Хуудас:	Хянасан огноо:		
			04	08	2020		



САРАВЧ, СҮҮДРЭВЧ

ХАРАГДАХ БАЙДАЛ



Тайлбар

– Хотын өнгө үзэмжийг тодорхойлохоос гадна саравч, сүүдрэвч нь нар салхинаас хамгаалах чухал хэрэгсэл тул нарны тусгалаас хамгаалах болон салхины чиглэлийг тооцоолж төлөвлөх шаардлагатай.

– Нийтийн хэрэгцээний нутаг дэвсгэрийг усан оргилуур, усан сан, шат, налуу зам, саравч, сүүдрэвч, гэрэлтүүлэг зэрэг архитектурын жижиг хэлбэрээр тоноглож тохижуулан төлөвлөнө (БНБД 30.0103–4.9).

МАТЕРИАЛЫН ТҮҮВЭР		
	Материалын нэр	Хөндлөн огтлол
1		
2		
3		
4		
5		
6		
7		


САРАВЧ, СҮҮДРЭВЧ			ХАРАГДАХ БАЙДАЛ		
	Архитектор	О.Билгүүн	Х.С-Дугаар: USC-14.02С	Масштаб: М1:20	Огноо: 2020
	Гүйцэтгэсэн	О.Билгүүн	Зургийн дугаар: 05 08 Хянасан огноо: 2020		
	Шалгасан	Б.Од-Эрдэнэ			

САРАВЧ, СҮҮДРЭВЧ

ХАРАГДАХ БАЙДАЛ




ХАЖУУ ТАЛ М1:200




БОЛОМЖИТ ХУВИЛБАРЧУД

НҮҮР ТАЛ М1:200



ДЭЭВРИЙН БАЙГУУЛАЛТ М1:200



	САРАВЧ, СҮҮДРЭВЧ	БОЛОМЖИТ ХУВИЛБАРЧУД			
Архитектор		О.Билгүүн	Х.С.-Дугаар: УС-14.02С	Масштаб: М1:200	Огноо: 2020
Гүйцэтгэсэн		О.Билгүүн	Зургийн дугаар: 06	Худас: 08	Хянасан огноо: 2020
Шалгасан		Б.Од-Эрдэнэ			